



ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО



ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

ҮНДСЭН ОЙЛГОЛТ



ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ

Экспорт, импортын
зөрүү



ГАДААД ХУДАЛДААНЫ НИЙТ ЭРГЭЛТ

Экспорт, импортын
нийлбэр



ОЛОН УЛСЫН ХУДАЛДАА

Улс орнуудын
хооронд
материаллаг үнэт
зүйлс, үйлчилгээ
нийлүүлэх үйл
ажиллагаа



ЭКСПОРТ

Олон улсын
худалдаанд бараа
товар буюу ямар
нэг үйлчилгээг
гадаад оронд
гаргаж зарах



ИМПОРТ

Олон улсын
харилцаанд бараа
үйлчилгээний
бүтээгдэхүүнийг
оруулах,
нэвтрүүлэх

ОЛОН УЛСЫН ХУДАЛДАА

Улс орнуудын хооронд материаллаг үнэт зүйлс болон үйлчилгээ нийлүүлэх техник үйл ажиллагааг зохион байгуулах хэрэгжүүлэхтэй холбогдсон онол болон практикийн цогц ойлголт юм. Олон улсын хооронд шинжлэх ухаан техникийн болон хамтын ажиллагааны үр дүнг худалдаа хийх замаар бараа, үйлчилгээний хэлбэрээр нийлүүлэхэд олон улсын худалдааны агуулга оршиж байдаг. ОУХ-ны үйл ажиллагаа нь үндсэн ба олон улсын бараа эргэлтийг хангах гэсэн хоёр төрөлд хуваагдана. ОУХ -ны субъект нь тухайн орны засгийн газрын эрх бүхий байгууллагаас гадаад худалдаа явуулах эрх авсан пүүс, байгууллагыг ойлгоно. Өнөө үед ОУХ-ны үндсэн субъектийн үүргийг Үндэстэн дамнасан корпорациуд /ҮДК/ тодорхойлох болсон бөгөөд эдгээр нь дэлхийн зах зээл дээрх худалдааны шинж байдалд асар их өөрчлөлтүүдийг оруулж байна.


ОУХ -НЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА


Худалдан авагчаа
хайж олох

Худалдааны гэрээ
байгуулах.


Гэрээг хэрэгжүүлэх
зэрэг юм.

ГАДААД ХУДАЛДААНЫ ХЭЛЦЛИЙН ҮЕ ШАТ





Экспорт-олон улсын худалдаанд бараа товар буюу ямар нэг үйлчилгээг гадаад оронд гаргаж зарах



Импорт-олон улсын харилцаанд бараа үйлчилгээний бүтээгдэхүүнийг оруулах, нэвтрүүлэх

ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЛИЙГ ХЭРХЭН ТООЦООЛОХ ВЭ?


- Бүтээгдэхүүний борлуулалтаас олсон орлогоос түүнийг үйлдвэрлэхэд зарцуулсан зардлыг хасаж үйлдвэрлэлийн ашиг алдагдлын хэмжээг тодорхойлдог
- Бараа үйлчилгээг гадаадад худалдах буюу экспортоос орлого орно.
- Гадаад худалдааны орлогоос(экспорт)гадаад худалдааны зардлыг(импорт) хасаж гадаад худалдааны ашиг алдагдлыг тодорхойлно.
- Гадаад худалдаа+ ашигтай
- Гадаад худалдаа- алдагдалтай

ҮЙЛ АЖИЛЛЛАГАА 4.8

Сурах бичиг-116 хуудас

Үзүүлэлт	2010 он	2012 он	2014 он	2016 он
Нийт эргэлт	?	?	?	?
Нийт экспорт	2908.5	4384.7	5774.3	4916.3
Нийт импорт	3200.1	6738.4	5236.7	3358.1
Гадаад худалдааны +ашиг(-алдагдал)	?	?	?	?

ГАДААД ХУДАЛДААНЫ НИЙТ ЭРГЭЛТ, ЭКСПОРТ, ИМПОРТ, ТЭНЦЭЛ, 2020.12 САР



ГАДААД ХУДАЛДААНЫ ОНОЛУУД

Давид Рикардо “Харьцангуй давуу талын онол”

Ямар ч бүтээгдэхүүнээр туйлын давуу талгүй улс олон улсын худалдаанаас ашиг олж болохыг тайлбарласан юм. Жишээ нь: Англи улс Португал улсаас вино импортоор авч, цэмбэ экспортлох нь ашигтай гэж үзсэн. Өөрөөр хэлбэл Англи улсад цэмбэ үйлдвэрлэхэд нэг жилийн хугацаанд 100 ажилчин шаардлагатай, вино үйлдвэрлэхэд 120 хүн шаардлагатай. Гэтэл Португалид вино үйлдвэрлэхэд 80 хүн шаардлагатай байв. Иймд Англи улсад вино оруулж ирээд цэмбэ гаргахад ашигтай. Харин Португалид бол вино гаргаад цэмбэ оруулах нь ашигтай байв.

Адам Смитийн “Туйлын давуу талын онол”

Бусад өрхийн бага зардлаар үйлдвэрлээд, хямдхан зарж буй бүтээгдэхүүн, үйлчилгээг тухайн өрх үйлдвэрлэх ямар хэрэгтэй вэ? гэсэн асуулт тавьсан байна.

Гадаад худалдаа хийгдэхэд дараах зүйлс шалтгаан нь болж байдаг гэж үздэг.

- Үйлдвэрлэлийн нөхцөлийн ялгаа
- Хэрэглэгчдийн сонирхолын ялгаа
- Технологи нь ялгаатай

Гурилыг А улс Б улсаас $4/3=1,3$ дахин бага Махыг Б улс А улсаас $6/3=2$ дахин бага зардлаар үйлдвэрлэж байна. Иймээс А улс гурилаар Б улс махаар туйлын давуу талтай байна.

ПРОТЕКЦИОНИЗМ ҮНДЭСНИЙ ЭДИЙН ЗАСГИЙГ ГАДААД ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ТЭЛЭЛТЭЭС ХАМГААЛДАГ ТӨРИЙН БОДЛОГО

ЗАХИРГААНЫ

ВАЛЮТЫН

СОНГУУЛИЙН

ХАМТЫН

ЯЛГАВАРГҮЙ

Төр бодлогоор аж
ахуйн нэгжид
хориг тавих

төрийн банк үндэсний
мөнгөн тэмдэгтийн
хөдөлгөөнийг хангах
зорилгоор

тодорхой салбар,
бүлэг аж ахуйн
нэгжид хориг
тавих

гуравдагч орнуудтай
холбоотой олон улсын
бүлгүүдийн
протекционизм.

бүх төрлийн
импортын гаалийн
татварын хувь
хэмжээг нэмэгдүүлэх

ПРОТЕКЦИОНИЗМЫН ТӨРЛҮҮД




**СОНГОМОЛ
ПРОТЕКЦИОНИЗМ -
ТОДОРХОЙ
БҮТЭЭГДЭХҮҮНЭЭС ЭСВЭЛ
ТОДОРХОЙ МУЖААС
ХАМГААЛАХ**



**АЖ ҮЙЛДВЭРИЙН
ПРОТЕКЦИОНИЗМ -
ТОДОРХОЙ САЛБАРЫГ
ХАМГААЛАХ**




**ХАМТЫН ПРОТЕКЦИОНИЗМ -
ЭВСЭЛД НЭГДСЭН ХЭД ХЭДЭН
ОРНЫ ХАРИЛЦАН
ХАМГААЛАЛТ**



**ДАЛД ПРОТЕКЦИОНИЗМ -
ГААЛИЙН БУС АРГЫН
ТУСЛАМЖТАЙГААР**



**ОРОН НУТГИЙН
ПРОТЕКЦИОНИЗМ - ОРОН
НУТГИЙН КОМПАНИУДЫН
БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭГ
ХАМГААЛАХ**



• ;
**НОГООН ПРОТЕКЦИОНИЗМ -
БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛИЙН
ТУСЛАМЖТАЙГААР**

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо 1."Гадаадын хөрөнгө оруулалт" гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж байгуулах, эсхүл Монголын аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчаас Монгол Улсад оруулж буй эд хөрөнгийн болон оюуны үнэт зүйлсийг хэлнэ.



ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

<https://www.youtube.com/watch?v=JwelzwkHrYg>

- ХО, ГХО, ГШХО
- ХО бол 10 төгрөгөө 11 болгох зорилгоор хөрөнгөө ямар нэг бизнес, бараа, төсөлд хийх.
- ГХО нь гадаадын этгээд 10 төгрөгөө 11 болгох зорилгоор 10 төгрөгөөрөө (эсвэл түүнтэй дүйцэх хөрөнгөө өгч) манай бондыг авах, эсвэл хүүтэй зээл болгох, эсвэл компанийн хувьцаа авах зэргийг хэлж байна.

Үүний дунд Ш үсэг хэзээ нэмэгдэх вэ гэхээр 10 төгрөг нь уг хөрөнгийг хүлээн авч байгаа талын бизнесийн удирдлагад “lasting interest” буюу тууштай ашиг сонирхол үүсгэх хэлбэрийг хэлнэ. Санхүүгийн зах зээл юм уу хувь хүнд биш Шууд л уг бизнест хөрөнгө, сонирхлоо оруулсан хэлбэр гэсэн үг.

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- **ХӨДӨЛМӨР ЭКСПОРТОЛДОГ ОРНУУД**

Нэг хүнд ногдох орлогын түвшнээр доогуур эсвэл ажилгүйдлийн түвшин өндөр орнууд ордог.

- **КАПИТАЛ ИМТОРТОЛДОГ ОРНУУД**

Үндэсний үйлдвэрлэлийн хөгжлийн түвшин дорой, байгалийн баялаг ихтэй, голдуу буурай хөгжилтэй орнууд орно.

- **ХӨДӨЛМӨРИЙН ЭКСПОРТ МОНГОЛД**

Монгол 3.2 сая хүнтэй, түүний 4.5 хувь нь гадаадад амьдарч байна. Дэлхийн 67 оронд 144,566 буюу Баянхонгор, Булган аймгуудын хүн амтай тэнцэх тооны монголчууд гадаадад амьдарч байна

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

КАПИТАЛЫН ЭКСПОРТ МОНГОЛД

Гадаадын хөрөнгө оруулалтын үндсэн хэлбэр нь хамтарсан үйлдвэрүүд барьж байгуулах явдал юм. Гадаадын хөрөнгө оруулагчид экспортын чадавхи өндөртэй уул уурхай, хурдан өсөлттэй байгаа харилца холбооны салбар болон санхүү-зээл, худалдаа, үйлчилгээний салбаруудад хөрөнгө оруулахыг илүүд үзэж байна.

АСУУЛТ

1. Хөгжингүй орнууд хөдөлмөр болон капиталын алийг нь импортолж, алийг нь экспортолж байна вэ?
2. Буурай хөгжилтэй орнууд хөдөлмөр болон капиталын алийг нь импортолж, алийг нь экспортолж байна.
3. Манай орны хувьд хөдөлмөр болон капиталын алийг нь экспортолж, алийг нь импортолж байна вэ? Эдгээрийн шалтгаан нь юу байж болох вэ?

2022 он гарсаар манай улсын 24 мянган иргэн гадаад руу ажиллах, суралцах болон байнга оршин суух зорилгоор явжээ

Зорчсон улсын нэр	2019 I-III	2020 I-III	2021 I-III	2022 I-III
Бүгд	548 802	221 580	89 887	63 379
Австрали	1 490	763	18	596
АНУ	3 350	2 045	354	1 840
АНЭУ	572	254	14	968
БНСУ	23 720	15 766	1 114	4 295
БНХАУ	408 383	131 165	85 298	30 362
ОХУ	75 731	44 488	1 523	6 365
Тайланд	4 517	1 962	5	3 443
Турк	1 543	2 834	140	7 527
ХБНГУ	2 175	1 578	210	922
Япон	7 344	3 971	173	1 917
Бусад	19 977	16 754	1 038	6 984

Шууд хөрөнгө оруулалт-Компани
бүтээгдэхүүн
экспортлохын оронд
гадаадад үйлдвэр байгуулах
эсвэл худалдан авна

Портфелийн хөрөнгө оруулалт-
Тухайн орны үнэт цаасыг
гадаадын худалдан авагчдад
худалдана.

МУ нэг хүнд ногдох ҮНО-ын түвшнээр дунджаас доогуур орлоготой орны ангилалд багтаж байна


Дэлхийн эдийн засгийн форумын гаргасан судалгаагаар өрсөлдөх чадвар 138 орноос 102-т байна.

Монголд хөдөлмөрийн насны 10 хүн тутмын 1 нь ажилгүй байна.

Монгол Улс ашигт малтмалын нөөцөөр дэлхийд эхний 10-т жагсдаг бөгөөд манай оронд 80 төрлийн ашигт малтмалын 1170 орд, 8000 гаруй илрэл бүртгэгдсэн байна. Үүнд алтны 1619, мөнгөний 227000, зэсийн 36,3 сая, төмрийн хүдрийн 660 сая, цайрын 5,9 сая гэх мэт

ҮНДЭСТЭН ДАМНАСАН КОРПОРАЦИ

- Үндэстэн дамнасан корпораци (ҮДК, англ. Multinational corporation) гэж хоёр болон түүнээс олон улсад үйлдвэрлэлийн салбартай юм уу үйлчилгээгээ явуулдаг корпораци (компани) юм. Үйлдвэрлэлийн боломжоо хэрхэн зохион байгуулснаас нь хамааруулж үндэстэн дамнасан корпорациудыг дараах үндсэн гурван бүлэгт хувааж үздэг:
 - 1. Хэвтээ зохион байгуулалттай ҮДК-ийн янз бүрийн улсад орших үйлдвэрлэлийн салбарууд нь хоорондоо ижил буюу төсөөтэй бүтээгдэхүүн гаргадаг.(Үүний жишээнд Макдональдс орно)
 - 2. Босоо зохион байгуулалттай ҮДК-ийн тодорхой нэг буюу хэд хэдэн улсад орших үйлдвэрлэлийн салбарууд нь нөгөө улс буюу улсуудад байрлах үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагаанд хэрэглэх бүтээгдэхүүнээ үйлдвэрлэдэг.(Үүний жишээнд Адидас орно)
 - 3. Олон талт үйл ажиллагаатай ҮДК-ийн үйлдвэрлэлийн салбарууд төрөл бүрийн улсуудад байдаг боловч хэвтээ, босоо аль нэг байдлаар холбоотой биш (Үүний жишээнд Майкрософт орно)



Аливаа компани 6 үе шаттайгаар ҮДК болон хөгждөг.

- Гадаадад бүтээгдэхүүнээ экспортлох
- Гадаад зах зээлд борлуулалтын салбар нэгжээ ажиллуулах /дистрибьютор/
- Гадаадын компаниудад know-how, патент, барааны тэмдэг зэргийг лицензээр ашиглуулах
- Гадаадад өөрийн үйлдвэрлэлээ явуулах
- Улс хооронд үйлдвэрлэлээ өргөтгөн удирдах
- Хөрөнгийг улс хооронд эзэмших буюу ҮДК

ГЭРИЙН ДААЛГАВАР

**117-128-р хуудасны агуулгыг унших,
чухал ойлголтуудыг тэмдэглэх**

Үйл ажиллагаа 4.10, 4.12, 4.13. 4.16

**Хичээлийн агуулгатай холбоотой мэдээллийг
сонирхон судлаж дүгнэлт бичээрэй.**